




ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Аймгийн аж үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга 2018 онд



www.Khuvsgul.nso.mn

АГУУЛГА

Ойлголт, тодорхойлолт

1. Хөвсгөл аймгийн аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үүсэл хөгжил
2. Аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо
3. Аймгийн аж үйлдвэрийн салбар
4. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дүгнэлт

Ашигласан материал

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбар: эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудын тоо, ажиллагсад, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээгээр болон үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, тухайн болон өмнөх жилийн тайлан тооллого судалгааны материал болно.

Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн: аж үйлдвэрүүдийн газруудын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны шууд бөгөөд ашигтай үр дүн юм. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессын дүнд үйлдвэрлэгдсэн хэрэгцээний өртгийн нийлбэр цогцыг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гэнэ.

Барилга угсралт, их засвар: барилга барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа юм.

Худалдааны нийт үйлдвэрлэл: бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа /хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг/-аас орсон орлого, бусад орлого /үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй/-ыг оруулна.

Худалдааны нийт борлуулалт: тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтыг оруулах бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно. Цэвэр борлуулалт /электрон худалдааны борлуулалтыг оруулаад/-ыг тооцохдоо нийт борлуулалтаас борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хасна.

Нийт цэгийн тоо: тайлант хугацаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо, албан бус секторт хамрагдах цэг /чингэлэг, түргэн үйлчилгээний цэг, лангуу, гутал засвар, авто засварын газар зэрэг/-үүдийг хамруулна.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо: тайлант хугацааны суурин хүн амын жилийн дундаж тоог тухайн хугацааны худалдааны салбарын нийт цэгийн тоонд харьцуулж тодорхойлно.

Ачаа эргэлтийг: тээвэрлэсэн ачааг тээсэн зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцоно.

Зорчигч эргэлтийг: зорчсон зорчигчдын тоог аялсан зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцно.

Суурин телефон цэг: гэдэг нь нийтийн телефон сүлжээнд хэрэглэчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэчийг хэлнэ.

Үүрэн утас хэрэглэгч: гэж цахилгаан холбооны нийтийн сүлжээнд хөдөлгөөнт технологийг ашиглан холбогдох боломж бүхий хэрэглэгчдийг ойлгоно. Утасгүй холбооны хэрэглэгч: гэж тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгчийг ойлгоно.

Сансрын холбооны хэрэглэгч: гэж сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.

1. ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Хөвсгөл аймгийн аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил

Хөвсгөл нутаг нь хувьсгалын өмнөх Халхын гурван аймаг, Шавь зэрэг дөрвөн газрын уулзвар нийлсэн онцлог хязгаар байв. Хөвсгөл аймгийн олон ястны дотор гар үйлдвэрлэл бие даасан салбар болж хөгжөөгүй байсан тул зөвхөн гэр зуурын туслах үйлдвэрлэлийн шинжтэй байжээ. Хүмүүс мал маллахын завсарт босон суун хийдэг өөрсдийн ойр зуурын хэрэгцээний зүйлийг бэлтгэх зорилготой байсан. Гар урлалын ажилд бас мэргэжлийн ялгавар байжээ. Гэрийн мод хаалга, тооно, унь, хана хийх, эмээлийн мод, тэрэг чарга хийх, модон сав суулга хийх, авдар сав, шүүгээ модон ор, ширээ сандал бэлтгэх, байшин барилга барих хүртэл бүхий л ажлыг модны мужаан хүмүүс гүйцэтгэж, тэднийг мод цавчирдана хэмээн данс бүртгэлд тэмдэглэж XVIII-XIX зууны үед Хөвсгөл нутагт олон тооны модчин, тэрэгчин, эмээлчин, уран сийлбэрчид, байшин барилга, дуган сүм урлаачид төрөн гарч эд зүйлийг бүтээж босгож байжээ.

Мөн урчууд модоор талхи, хэдрэгэ, эмээл, янгирцаг, эрвээлж, дөрөө, эргүүлэг, чагт, тэмээний шат, үхрийн буулга, сааль, нум сум гэх зэрэг олон зүйл хийж байжээ.

1936 оны 1 сард Хөвсгөл аймагт гар үйлдвэрийн хоршооллын төлөөлөгчийн газар байгуулагдаж, 1937 онд Бүрэн, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Рашаант сумдад 82 урчуудтай гэрээ байгуулж модон тэрэг, гэрийн мод, гутал зэрэг эд бараа захиалан үйлдвэрлүүлж бүтээгдэхүүнээ борлуулан ашиг олж эхэлжээ.

Хөвсгөл аймагт аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд их анхаарал тавьж ЗХУ-ын тусламжаар 1961 оны 6 сарын 27 нд Мөрөн хотод гурилын үйлдвэр ПТС-1200 маркийн илчит цахилгаан станц, 6-Ч-36/45 маркийн дизель станц бүгд 830 квт-ын хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллаж, 1966 оны 8 сараас биеэ даасан эрчин хүчний үйлдвэр болон хөгжжээ. 1966 оны 3 сард Эгийн голын нүүрсний уурхай нээгдэж ажиллав. Аймгийн үйлдвэрлэлийн хоршооллын суурин дээр 1972 оны 3 сард Мөрөн, Хатгал, Цагаан-Үүр, Тариалангийн модон үйлдвэрлэлийн тасаг, ойн аж ахуйн мод бэлтгэлийн бригад зүсмэлийн тасгийг нэгтгэн Мөрөн хотын мод боловсруулах үйлдвэрийг байгуулжээ. Мөн 1979 онд Хатгалын модны үйлдвэрлэлийн цех, 1980 онд Мөрөнгийн гэрийн мод, гэр аж ахуйн модон эдлэл үйлдвэрлэх цехийг ашиглалтанд оруулжээ. Мөн 1972 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар байгуулагдав. 1990 онд аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 7.5 дахин өссөн дүнтэй байсан боловч үйлдвэрлэлийн чанар, үр ашгийг дээшлүүлэх бололцоог ашиглаж чадаагүй дутагдал байсаар байв.

Аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1990 онд 81.7 сая төгрөг байсан бол 2000 онд 2357.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2358.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөц харахад 37.9 дахин нэмэгдсэн мэт харагдах боловч энэ хугацаанд мөнгөний ханшийн уналтыг хамгийн багаар 200 дахин унасан гэж үзвэл 2000 онд үйлдвэрлэж гаргасан аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 1990 оноос өмнөх үеийн төгрөгийн ханшаар бодож үзвэл 11.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж 1990 оны түвшингөөс 7-8 дахин буурсан байна.

1994 оны байдлаар Хөвсгөл аймагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулахаар 600 гаруй аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдсэн байна. 1999-2000 онуудад эдгээр газруудын тоо 376-332 байснаас байнгийн ажилтай нь 136-145 байжээ.

Хөвсгөл аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын үүсэл хөгжил

Ардын хувьсгал ялахаас өмнө Хөвсгөлийн хязгаар нутагт гадаадын худалдаа, мөнгө хүүлэгч 100 гаруй салбар пүүс ажиллаж байв. Хувьсгалын дараа 1921 оны

сүүлчээр Ардын харилцан туслалцах хоршоог анх байгуулж, 1922 оны эхээр Хатгалд ард иргэдэд үйлчлэх худалдааны салбар байгуулагдсан нь тус аймагт худалдааны байгууллага буй болох үндэс суурь болсон байна. Анхны хоршоог эд бараагаар хангах гэж 30 гаруй тэмээн жингээр 79 мянган лан мөнгөний үнэ бүхий цай, даалимба, цуу ямбуу, дүнсэн тамхи зэрэг эд бараа ачин авчирч байжээ.

Хоршооны салбар хөдөө орон нутагт байгуулагдаж байсны дотор Мөрөнгийн хүрээнд 1923 онд салбар байгуулагдаж, Сар толгой, Жалханз, Бүгсийн хүрээнд жижиг дэлгүүр нээгджээ. 1927 онд хоршооны салбар 7 болж 373 мянган төгрөгийн бараа борлуулж, 300 гаруй мянган төгрөгийн ноос, түүхий эд цуглуулан авсан байна.

1931 онд аймаг байгуулагдсаны дараа хоршооны салбарын тоо 15-д хүрч, худалдаа наймааны эргэлт ихсэж, ард иргэд бэлтгэлийн зүйлээ дэлгүүр хоршоонд өгөх нь нэмэгдсэн. 1934 онд Монгол Оросын хамтарсан центрсоюз хэмээх худалдааны байгууллагын суурин дээр аймгийн хоршоодын холбоо байгуулагдсан. 1940 он болоход Хоршоодын холбооны харьяанд анхны хоршоо 15, сумын салбар хоршоо 6, дэлгүүр 43, агент, ганзагын наймаа хийгчдийн тоо 538-д хүрч, бараа гүйлгээ 5.3 сая төгрөг болж, 2.1 сая төгрөгөөр бэлтгэлийн зүйл худалдан авч байв.

Аймгийн хоршоодыг холбоог 1958 онд өөрчлөн байгуулж, худалдаа бэлтгэлийн ангитай болсон. Худалдааны байгууллагын хүрээ өргөсөн номын худалдаа, бөөний худалдааны бааз, нийтийн хоолны газар байгуулагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ нь улам өргөн болж материаллаг бааз сайжирсан юм.

1980-аад онд аймгийн худалдааны байгууллага бараа, түүхий эдийн 156 агуулах, мах ногооны 37 зоорь, төрөл бүрийн үйлчилгээний зориулалтын 50 шахам машин трактортай, худалдааны мэргэжилтэй боловсон хүчин, мэргэшсэн ажилчдаар хангагдсан байлаа.

1990-ээд оны эхнээс төвлөрсөн хангамжийн тогтолцоо задарч, худалдаа үйлчилгээний бүх байгууллага хувьчлагдаж, зах зээлийн шинэ орчин бий болж, үйлчилгээний шинэ хэлбэрт шилжсэн. Өнгөрсөн 20 шахам жилд зах зээлийн үеийн худалдаа, үйлчилгээний шинэ хэлбэр бүрэлдэн тогтож, худалдаа, түүхий эд бэлтгэл, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээг бүрэн хувийн хэвшлийнхэн гүйцэтгэх болсон.

2. АЙМАГТ БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

Аймгийн хэмжээнд 2148 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэнээс үйл ажиллагаа явуулж байгаа 1648 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа нь түр зогссон 500 аж ахуйн нэгж байгууллага байна.

2.1 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, сумаар, 2018 он


Сумдын нэр	Бүгд	үүнээс:					
		үйл ажиллагаа явуулж байгаа	үйл ажиллагаа явуулаагүй	үүнээс:			
				эхлээгүй	түр зогсоосон	бүрэн зогсоосон	бусад
Бүгд	2327	1732	594	254	297	38	5
Алаг-Эрдэнэ	100	77	23	13	9	1	-
Арбулаг	30	20	10	3	7	-	-
Баянзүрх	36	30	6	1	4	1	-
Бүрэнтогтох	62	55	7	2	5	-	-
Галт	68	53	15	5	10	-	-
Жаргалант	58	43	15	7	8	-	-
Их-Уул	63	47	16	6	9	1	-
Рашаант	43	31	12	7	4	1	-
Ренчинлхүмбэ	39	32	7	1	6	-	-
Тариалан	89	64	25	7	13	5	-
Тосонцэнгэл	62	53	9	6	3	-	-
Төмөрбулаг	47	31	16	6	6	4	-
Түнэл	50	38	12	7	4	1	-
Улаан-Уул	49	42	7	2	5	-	-
Ханх	44	31	13	6	6	1	-
Цагаан-Уул	47	35	12	6	6	-	-
Цагаан-Үүр	35	24	11	2	7	2	-
Цэцэрлэг	76	57	19	10	7	2	-
Чандмань-Өндөр	39	30	9	1	8	-	-
Шинэ-Идэр	40	29	11	7	4	-	-
Мөрөн	1160	843	317	142	151	19	5
Эрдэнэбулган	53	37	16	5	10	1	-
Цагааннуур	37	30	17	2	5	-	-

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, борлуулалт

Хөвсгөл аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 28.2 тэрбум төгрөгт хүрсний 13.4 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт, 86.6 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт ногдож байна.

Зураг 3.1 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, борлуулалт, сая.төг, 2009-2018 он



Аж үйлдвэрийн газрууд 2018 онд 28214.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 26124.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулав. 2017 оны мөн үеэс нийт бүтээгдэхүүн 1.3 хувь, бүтээгдэхүүний борлуулалт 5.2 хувиар тус тус буурсан байна.

3.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төг, 2016-2018 он

Салбараар	2016	2017	2018
Бүгд	16809080.6	16583535.3	28214066.9
Нүүрс олборлолт	1428900.0	1826355.3	3779655
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	2733138.0	2786726.5	7187993.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	-	2852350.0	3941044
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9438889.9	5086894.0	5897084.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	2348326.8	3693742.9	6181072.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	15400.0	4900.0	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	209757.1	60690.0	-
Мод, модон эдлэл	160581.0	226310	159822

Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	11305.2	15417.6	21385.5
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	-	5123.0	2740.6
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	-	-	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	-	25026.0	-
Ус ариутгал, усан хангамж	462782.6	-	1043268.9

Хөвсгөл аймагт нүүрсний борлуулалт 2011 онд 677.1 сая төгрөг байсан бол 2018 онд 26124.5 сая төгрөг болж, 38.6 дахин, өмнөх оноос 57.5 хувиар тус тус өссөн байна.

3.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, сая төг, 2015-2017 он

Салбараар	2016	2017	2018
Бүгд	18211617.8	17268507.8	26124544.9
Нүүрс олборлолт	1818829.1	2489889.2	4323209.1
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	2871329.8	2530076.5	6984623.8
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	-	3040900.0	4416724.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10108934.0	5174849.9	6007808.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	2549036.8	3690013.2	3164242.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	17400.0	4900.0	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	210407.1	60690.0	-
Мод, модон эдлэл	161339.0	230845.0	160237
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	11559.4	15838.0	21385.5
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	-	5480.0	2477.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	-	-	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	-	25026.0	-
Ус ариутгал, усан хангамж	462782.6	-	1043568.9

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох талх, нарийн боов, ундаа, архи, чихэр, дулаан, гурил бүтээгдэхүүнүүдийг өөрсдөө үйлдвэрлэж аймгийнхаа дотоодын хэрэгцээг хангадаг. Харин цахилгааны хувьд 100% Орхон аймгаас хараат байдаг Завхан аймгийг нүүрсээр хангадаг болно. Манай аймаг аялал жуулчлалын гол бүс нутаг тул гадаад, дотоодын жуулчид иргэдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүнүүдийг сонирхон авдаг.

3.3 ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2012-2018 он


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	АҮ-н гол нэр төрлийн бүтээгдэхүүн					
		2014	2015	2016	2017	2018	2018/2017
Түгээсэн ус	мян.м.куб	161.9	138.4	95.7	-	214.1	-
Нүүрс	мян.тн	48.4	60.8	43.3	55.3	114.5	107.1

Хөвсгөл аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга

Зүсмэл	мян.мЗ	1.6	1.9	0.7	1.7	0.5	-70.9
Дэр	мян.ш	1.9	2.4	4.2	1.5	1.0	-30.7
Монгол дээл	ш	157	261	265	43	66.0	53.5
Савхин гутал, ботинк	хос	94	72	29	569	-	-
Монгол гутал	хос	8	2	-	5	-	-
Буриад гутал	хос	240	625	122	92	31.0	-66.3
Махан консерв	тн	11.4	46.3	41.7	3.9	4.3	10.8
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	тн	1.9	17.1	82	-	-	-
Малын тэжээл	мян.тн	1.5	1.4	0.6	0.7	2.1	201.5
Тараг	мян.л	26.2	7.9	7.8	4.7	1.1	-76.6
Талх	тн	1065.8	1273.6	1169.6	686.3	569.6	-17.0
Жигнэмэг	тн	-	-	-	7.6	15.7	-59.0
Нарийн боов	тн	437.4	546.8	655.8	838.3	811.5	10.2
Ундаа	мян.л	50	53.4	29.4	-	-	-
Жүүс	мян.л	-	1.7	29.4	11.5	15.8	-15.3
Архи	мян.л	60.9	32.2	-	-	46.5	20.2
Чихэр	тн	2.5	1.3	6.2	3.8	1.1	-51.1
Гурил	тн	2100	4038.3	5413.4	5237.3	7373.9	132.6
Хэрчсэн гурил	тн	-	-	44.6	53.1	-	-
Цай	кг	28960	46861.5	20089.3	29830.9	52469.4	106.1
Маягт	мхдх	250	412	216.6	202.4	69.6	36.7


Аймгийн чулуун нүүрсний нийт олборлолт 2018 онд 114.5 мян.тн болж өмнөх оны мөн үеэс 107.1 хувиар өссөн байна.

Зураг 3.2 Чулуун нүүрс олборлолт / мян.тн /, 2010-2018 он



Аймгийн талх, нарийн боовны нийт үйлдвэрлэлт 2010 онд 633.7 тн байсан бол 2018 онд 1381.1 тн болж, 2010 онтой харьцуулахад 2.2 дахин өссөн, харин өмнөх оноос 2.9 хувиар буурсан байна.

Зураг 3.3 Талх, нарийн боовны үйлдвэрлэлт / тн /, 2009-2017 он



ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 2327 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлснээс үйл ажиллагаа явуулж байгаа 1732 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа нь түр зогссон 594 аж ахуйн нэгж байгууллага байна.

Хөвсгөл аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 28.2 тэрбум төгрөгт хүрсний 13.4 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт, 86.6 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт ногдож байна.

Ашигласан материал

1. Хөвсгөл аймгийн нийгэм,эдийн засгийн танилцуулга 2009-2018 он
2. Сарын аж үйлдвэрийн мэдээ
3. Монгол улсын статистикийн эмхтгэл
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn